



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

Хот хоорондын нийтийн тээвэрлэлтийн  
чиглэл тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Говь-Алтай аймгийн Засаг даргын 2017 оны 1/1260 тоот албан бичгээр ирүүлсэн саналтай зөвшилцсөний үндсэн дээр Улаанбаатар – Говь-Алтай аймгийн Тонхил сум – Улаанбаатар хот хоорондын нийтийн тээвэрлэлтийн чиглэлийг тогтоож, ХХ86 чиглэлийн зураглалыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх чиглэлийн зорчигч урсгалыг тооцож, үйлчилгээний цагийн хуваарь, давтамжийг тогтоон тээвэрлэлтийг зохион байгуулахыг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ /П.Дэлгэрнаран/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт–шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Батболд/-т тус тус даалгасугай.

САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 288 тоот тушаалын хавсралт

УЛААНБААТАР – ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТОНХИЛ – УЛААНБААТАР ХОТ-ХООРОНДЫН НИЙТИЙН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЧИГЛЭЛИЙН ЗУРАГЛАЛ

Чиглэлийн дугаар: ХХ86

Чиглэлийн урт: 1247 км

Улаанбаатар хот

